

Living the Lotus 6

Buddhism in Everyday Life

2026
VOL. 249



РКК, Лос-Анжелас салбар

Living the Lotus Vol. 249 (2026.06)

Ахлах редактор: Маэда Такаши
Орчуулсан: Ж.Гэрэлтуяа
Хэвлэсэн: Рисшо Косей Кай, ОУХ
Хаяг: Fumon Media Center, 2-7-1
Wada, Sugunami-ku, Tokyo 166-8537 Japan
TEL: +81-3-5341-1124
FAX: +81-3-5341-1224
Email: living.the.lotus.rk-international@
kosei-kai.or.jp

Рисшо Косей Кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо, хамтран үндэслэгч Наганума Мёокоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Лянхуан Гурамсан Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгууль гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Бид тус байгууллагын ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн энх тайвны үйлсэд хувь нэмэр оруулж байна.

Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнтэй амьдралыг туулцаага гэсэн хүсэл шингэсэн билээ. Энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутамдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.

Бэрхшээл бол амьдралын нөхөр

Рисшо Косей Кай, ерөнхийлөгч
Нивано Ничикоо



Зовлонг бид өөрсдөө бий болгодог

Би өмнө хэд хэдэн удаа “тал аяга усыг ямар өнцгөөр харж, хүлээж авах вэ” гэж та бүхнээс асууж байсан. Зохиолч Кобаяши Сэйкан гуай “тал л аяга ус байна” гэж чамлах, “тал аяга байгаа нь ашгүй дээ” гэж баярлах, “хэн нэг нь тал аяга ус үлдээжээ” гэж талархаж харах өнцгүүд бий гэж хэлсэн. Аль ч өнцгөөр нь хүлээж авсан, яаж ч харсан бай тэгж харж байгаа хүн бол би өөрөө бөгөөд бодит зүйл бол “тал аяга ус” л байгаа юм. Тэгэхээр чамлах уу, баярлах уу, талархах уу гэдэг бүгд миний өөрийн сэтгэлээс л шалтгаалдаг гэсэн байгаа юм.

Эгэл сүсэгтэн хүмүүс бидний хувьд бурхны сургаал аль болох ойлгомжтой, амьдралд ойр байх чухал гэж би боддог юм. Энэ Кобаяши гэдэг зохиолч буддын “Зүрхэн Судар”-т айлддаг “бүх юмс дүрсгүй хоосон” гэх сургаалд тулгуурлан жаргалыг ч, зовлонг ч, бүх юмс үзэгдлийг хүмүүс бид өөрсдөө өөрийн харах өнцгөөр тодорхойлж, нэг бол баярлаж хөөрч, нэг бол гуньж гутран сэтгэл хөдлөлд автаж байдаг гэж сургадаг. Ялангуяа зовлон бэрхшээлийн шалтгааныг бид өөрсдөө тогтсон, нэг талыг барьсан үзэл, буруу бодол, сэтгэлийн төөрөгдөл, хүсэл шуналын улмаас бий болгох нь их байдаг учраас “тэр үзэл баримтлал, харах өнцгөө өөрчлөх юм бол амьдрал илүү амар болно” гэсэн энэ тал аяга усны жишээ бол бурхны сургаалаар харах өнцгөө өөрчлөх амьдралд ойрхон сургаал гэж би боддог юм.



Зовлон бэрхшээл ч гэсэн амьдралын чухал мөч

Кёотогийн их сургуулийн захирал асан Хирасава Ко гуайн “Төрөх, өтлөх, өвдөх, үхэх гэдгийг дөрвөн зовлон гэдэг боловч би бол дөрвөн жаргал гэж боддог” гэх үг бий. Харах өнцгөө өөрчлөх юм бол эдгээр нь бүгд хэрэгтэй зүйл гэсэн байгаа юм.

Өвчинг бид зовлон гэж боддог бол яруу найрагч Сакамүра Шинмин “Өвчин өөр нэгэн ертөнцийг надад нээж өгсөн” хэмээн талархан бичсэн байдаг. Мөн зохиолч Шимомүра Кожин “Миний амьдрахыг хүсдэг ертөнц бол зовлон бэрхшээл нь хүнийг сэтгэлээр унагах бус харин урам зориг өгдөг тийм ертөнц” гэсэн хэлсэн. Өмнө дурдсан Кобаяаши гуай аягатай усны жишээгээр тайлбарласан “хоосон”-ны сургаалын талаар “Шагжамүни бурхан нэгэн ижил юмс үзэгдлээс хэрхэн баяр хөөр, аз жаргалыг олж харж болох вэ гэдгийг бидэнд ойлгуулахыг хүссэн болов уу” гэж хэлсэн. Үнэхээр л зовлон гэж бодогдох зүйлийг амьдрах эрч хүч авах, амьдралаа өөрчлөх боломж гэдэг талаас нь харж, хүлээж авч болно. Харин зөвхөн нэг талаас нь харж, хэцүү байна л гэж бодоод байвал тэр зовлон үгүй болохгүй, түүгээр дамжуулж өөрийгөө хөгжүүлэх боломжийг алдах юм.

Гэхдээ мэдээж хэрэг үнэхээр хэцүү шаналж байхад хүчээр түүнийг эерэгээр харах хэрэгтэй гэсэн юм биш. Аливаа зүйлийг олон талаас хардаг байх, мөн хэчнээн хэцүү бэрхшээл байсан ч туйлын үнэн, шүтэн барилдлагын сургаалаар харах юм бол өөрт хэрэгтэй, шаардлагатай зүйл байдаг. Түүгээр ч үл барам балчир хүүхэд амьдралын туршлага хуримтлуулан насанд хүрдэг шиг зовлон бэрхшээл нь биднийг хөгжүүлж, ирээдүйн амьдралд нөлөөлдөг. Цаг хугацаа орж магадгүй ч гэлээ бэрхшээлийг амьдрах эрч хүч, баяр баясал болгож хувиргах хүч чадвар бидэнд бий.

Нэг зохиолд “Сайн, муу бүх зүйл одоогийн биднийг бүтээдэг. Бэрхшээл байхгүй байсан бол одоогийн чи байхгүй байх байсан. Сайхан зүйл байхгүй байсан бол одоогийн чи байхгүй байсантай яг адилхан” гэж бичсэн байсан. Тиймээс зовлон бэрхшээл ч гэсэн амьдралын чухал нэг мөч бөгөөд амьдралд хэрэгтэй туршлага юм. “Өнгөрсөн цаг хугацаанд хуримтлуулсан туршлага одоог бүтээдэг юм бол цаашдын ирээдүйнхээ загварыг одооноос гаргаж болох ба ингэснээр ирээдүйг ч, өнгөрсөн цаг хугацааг ч өөрчилж болно” гэж онолын физикч Сажу Харүо гуай хэлсэн байдаг. Тэр утгаараа өнгөрсөн үеэс хуримтлуулсан зовлон бэрхшээл, аз жаргал аль алиныг нь амьдралынхаа нөхөр гэж бодож, ирээдүйн би, ирээдүйн дэлхий ертөнцийн төлөө “одоо”-г чухалчлан амьдарцгаая.




Rissho Kosei-kai International

Make Every Encounter Matter



🌸 A Global Buddhist Movement 🌸



Information about local Dharma centers



facebook



X



✉ We welcome comments on our newsletter Living the Lotus: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp